



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/232/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdeneega@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитор: Г.Мөнхбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
1. 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2. 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
3. 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
4. 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан.....	9
5. 3.1 Ерөнхий зүйл.....	9
6. 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
7. 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
8. 3.4 Материаллаг байдал .....	10
9. 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
10. 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	11
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	11
3.6.3 Нэмэлт төсөв .....	11
11. 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
12. 3.8 Аудитын гол асуудал .....	11
13. 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	12
14. 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
15. 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
16. 4.1 Залруулсан алдаа.....	12
17. 4.1 Албан шаардлага.....	12
18. 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

№ \_\_\_\_\_  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАДИО,  
ТЕЛЕВИЗИЙН СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Г.ПУНЦАГБАЛЖИР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Радио, телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Радио, телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>319,396,995.44</b>	<b>309,786,263.23</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>17,620,745.14</b>	<b>5,768,336.93</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>144,402.00</b>	<b>511,302.00</b>
31110	Төгрөг	144,402.00	511,302.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>17,476,343.14</b>	<b>5,257,034.93</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>17,476,343.14</b>	<b>5,257,034.93</b>
31211	Төрийн сангийн харилцах	17,476,343.14	5,257,034.93
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,631,748.00</b>	<b>2,131,748.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,631,748.00	2,131,748.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>299,144,502.30</b>	<b>301,886,178.30</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>299,144,502.30</b>	<b>301,886,178.30</b>
35410	Бичиг хэргийн материал	413,900.00	486,000.00
35420	Аж ахуйн материал	3,977,495.00	3,939,162.00
35430	Сэлбэг хэрэгсэл	281,706,582.90	278,803,762.90
35440	Түлш, шатах тослох материал	1,938,619.00	2,957,788.00
35470	Бусад хангамжийн материал	11,107,905.40	15,699,465.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,849,600,227.45</b>	<b>3,604,185,745.87</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,849,600,227.45</b>	<b>3,604,185,745.87</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,070,111,227.45</b>	<b>824,696,745.87</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	244,466,790.00	244,466,790.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,498,772.88	-24,748,159.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,186,934.20	45,186,934.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,262,918.85	-24,794,074.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,660,402,215.92	3,713,782,715.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		2,849,889,444.91	3,134,443,928.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,038,233.90	19,517,497.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,331,809.93	-14,271,030.19
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,779,489,000.00</b>	<b>2,779,489,000.00</b>
39301	Програм хангамж	2,270,000.00	2,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,270,000.00	-2,270,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,779,489,000.00	2,779,489,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,168,997,222.89</b>	<b>3,913,972,009.10</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,168,997,222.89</b>	<b>3,913,972,009.10</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,168,997,222.89</b>	<b>3,913,972,009.10</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,061,676,958.00	4,061,676,958.00
51101	Өмч: - төрийн	4,061,676,958.00	4,061,676,958.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-248,365,489.31</b>	<b>-503,390,702.51</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-248,365,489.31	-248,365,489.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-255,025,213.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	355,685,754.20	355,685,754.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,168,997,222.89</b>	<b>3,913,972,009.10</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>433,702,289.99</b>	<b>362,926,594.03</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>131,648,041.99</b>	<b>48,839,864.03</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>131,648,041.99</b>	<b>48,839,864.03</b>
120002	Хүүгийн орлого	107,575.16	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	131,540,466.83	48,839,864.03

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,931,748.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,320,000.00	1,320,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	125,288,718.83	47,519,864.03
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>302,054,248.00</b>	<b>314,086,730.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>302,054,248.00</b>	<b>314,086,730.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	302,054,248.00	314,086,730.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>629,804,268.56</b>	<b>617,951,807.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>629,804,268.56</b>	<b>617,951,807.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>621,379,720.56</b>	<b>614,231,807.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>190,209,861.00</b>	<b>190,092,892.00</b>
210101	Үндсэн цалин	176,997,261.00	176,890,892.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,212,600.00	13,202,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,463,193.71</b>	<b>25,347,847.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,856,116.50	17,718,058.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,983,133.96	1,959,873.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,573,254.61	1,541,015.28
210204	Ажилгүйдлийн даатгал	368,246.12	375,355.31
210205	Эрүүл мэндийн даатгал	3,682,442.52	3,753,545.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,027,324.20</b>	<b>25,322,049.29</b>
210301	Гэрэл, цахилгаан	22,926,914.20	21,378,030.29
210302	Түлш, халаалт	3,756,160.00	2,763,519.00
210303	Цэвэр, бохир ус	624,250.00	412,500.00
210304	Байрны түрээс	720,000.00	768,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,639,188.00</b>	<b>12,037,423.00</b>
210401	Бичиг хэрэг	455,916.00	421,750.00
210402	Тээвэр, шатахуун	8,364,980.00	9,854,612.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	716,190.00	754,256.00
210404	Ном, хэвлэл	105,600.00	105,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	996,502.00	901,405.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,280,294.00</b>	<b>31,576,610.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,116,800.00	1,197,490.00
210604	Урсгал засвар	21,163,494.00	30,379,120.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,659,012.00</b>	<b>5,251,133.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,659,012.00	5,251,133.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,524,241.00</b>	<b>22,809,607.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,072,201.00	1,850,347.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,894,000.00	15,774,000.00
210807	Газрын төлбөр	5,558,040.00	5,185,260.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>317,576,606.65</b>	<b>301,794,245.61</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	520,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	317,576,606.65	301,274,245.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,424,548.00</b>	<b>3,720,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,424,548.00</b>	<b>3,720,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,424,548.00	3,720,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-196,101,978.57</b>	<b>-255,025,213.79</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-196,101,978.57</b>	<b>-255,025,213.79</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгсрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-248,365,489.31	4,168,997,222.89

D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-248,365,489.31	4,168,997,222.89
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-248,365,489.31	4,168,997,222.89
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-255,025,213.79	-255,025,213.79
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,061,676,958.00	355,685,754.20	-503,390,703.10	3,913,972,009.10

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>307,301,823.16</b>	<b>315,906,730.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,247,575.16</b>	<b>1,820,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,247,575.16</b>	<b>1,820,000.00</b>
120002	Хүүгийн орлого	107,575.16	00.00
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>5,140,000.00</b>	<b>1,820,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,820,000.00	500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,320,000.00	1,320,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>302,054,248.00</b>	<b>314,086,730.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>302,054,248.00</b>	<b>314,086,730.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	302,054,248.00	314,086,730.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>292,961,736.91</b>	<b>319,219,238.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>292,961,736.91</b>	<b>319,219,238.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>284,537,188.91</b>	<b>315,499,238.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>190,209,861.00</b>	<b>190,092,892.00</b>
210101	Үндсэн цалин	176,997,261.00	176,890,892.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,212,600.00	13,202,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,463,193.71</b>	<b>25,347,847.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,856,116.50	17,718,058.52
210202	Тэтгэмжийн даатгал	1,983,133.96	1,959,873.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,573,254.61	1,541,015.24
210204	Ажилгүйдлийн даатгал	368,246.12	375,355.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,682,442.52	3,753,545.11
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,869,583.20</b>	<b>26,211,218.29</b>
210301	Гэрэл, цахилгаан	22,926,914.20	21,378,030.29
210302	Түлш, халаалт	3,598,419.00	3,652,688.00
210303	Цэвэр, бохир ус	624,250.00	412,500.00
210304	Байрны түрээс	720,000.00	768,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,578,898.00</b>	<b>12,001,190.00</b>
210401	Бичиг хэрэг	653,716.00	493,850.00
210402	Тээвэр, шатахуун	6,371,980.00	9,784,612.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	716,190.00	754,256.00
210404	Ном, хэвлэл	148,600.00	105,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	688,412.00	863,072.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,232,400.00</b>	<b>33,265,350.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,399,540.00	5,299,450.00
210604	Урсгал засвар	3,832,860.00	27,965,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,659,012.00</b>	<b>5,251,133.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,659,012.00	5,251,133.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,524,241.00</b>	<b>22,809,607.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,072,201.00	1,850,347.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,894,000.00	15,774,000.00
210807	Газрын төлбөр	5,558,040.00	5,185,260.00

2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>520,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	520,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,424,548.00</b>	<b>3,720,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,424,548.00</b>	<b>3,720,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,424,548.00	3,720,000.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>14,340,086.25</b>	<b>-3,312,508.21</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>8,539,900.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>8,539,900.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>8,539,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	8,539,900.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-8,539,900.00</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>14,340,086.25</b>	<b>(11,852,408.21)</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,280,658.89</b>	<b>17,620,745.14</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>17,620,745.14</b>	<b>5,768,336.93</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	360,381,320.0	327,759,138.2	32,622,181.8	90.9
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	360,381,320.0	327,759,138.2	32,622,181.8	90.9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	356,381,320.0	324,039,138.2	32,342,181.8	90.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	206,019,480.0	190,092,892.0	15,926,588.0	92.3
210101	Үндсэн цалин	187,816,420.0	176,890,892.0	10,925,528.0	94.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,203,060.0	13,202,000.0	5,001,060.0	72.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,789,440.0	25,347,847.9	1,441,592.1	94.6
210201	Тэтгэврийн даатгал	18,548,616.0	17,718,058.5	830,557.5	95.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,060,208.0	1,959,873.7	100,334.3	95.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,648,154.0	1,541,015.2	107,138.8	93.5
210204	Ажилгүйдлийн даатгал	412,044.0	375,355.4	36,688.7	91.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,120,418.0	3,753,545.1	366,872.9	91.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,664,000.0	26,211,218.3	5,452,781.7	82.8
210301	Гэрэл, цахилгаан	25,896,000.0	21,378,030.3	4,517,969.7	82.6
210302	Түлш, халаалт	3,800,000.0	3,652,688.0	147,312.0	96.1
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.0	412,500.0	787,500.0	34.4
210304	Байрны түрээс	768,000.0	768,000.0	00.0	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,750,000.0	12,001,190.0	748,810.0	94.1
210401	Бичиг хэрэг	650,000.0	493,850.0	156,150.0	76.0
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.0	9,784,612.0	215,388.0	97.8

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.0	754,256.0	-4,256.0	100.6
210404	Ном, хэвлэл	150,000.0	105,400.0	44,600.0	70.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.0	863,072.0	336,928.0	71.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>47,150,000.0</b>	<b>41,805,250.0</b>	<b>5,344,750.0</b>	<b>88.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500,000.0	8,539,900.0	2,960,100.0	74.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,150,000.0	5,299,450.0	-149,450.0	102.9
210604	Урсгал засвар	30,500,000.0	27,965,900.0	2,534,100.0	91.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,000,000.0</b>	<b>5,251,133.0</b>	<b>748,867.0</b>	<b>87.5</b>
210702	Дотоод албан томилолт	6,000,000.0	5,251,133.0	748,867.0	87.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,458,400.0</b>	<b>22,809,607.0</b>	<b>2,648,793.0</b>	<b>89.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.0	1,850,347.0	2,149,653.0	46.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,894,000.0	15,774,000.0	120,000.0	99.2
210807	Газрын төлбөр	5,564,400.0	5,185,260.0	379,140.0	93.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>550,000.0</b>	<b>520,000.0</b>	<b>30,000.0</b>	<b>94.5</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.0	520,000.0	30,000.0	94.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,000,000.0</b>	<b>3,720,000.0</b>	<b>280,000.0</b>	<b>93.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,000,000.0</b>	<b>3,720,000.0</b>	<b>280,000.0</b>	<b>93.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.0	3,720,000.0	280,000.0	93.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>360,381,320.0</b>	<b>315,906,730.0</b>	<b>44,474,590.0</b>	<b>87.7</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>346,380,920.0</b>	<b>314,086,730.0</b>	<b>32,294,190.0</b>	<b>90.7</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	346,380,920.0	314,086,730.0	32,294,190.0	90.7
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>14,000,400.0</b>	<b>1,820,000.0</b>	<b>12,180,400.0</b>	<b>13.0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,000,400.0	1,320,000.0	12,680,400.0	09.4
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>17,620,745.14</b>	<b>-17,620,745.1</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>5,768,336.93</b>	<b>-5,768,336.9</b>	<b>-</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>22.00</b>	<b>21.00</b>	<b>01.0</b>	<b>95.5</b>
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	13.00	01.0	92.9
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	00.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн тайлан гараагүй болно.

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Радио, телевизийн сүлжээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад аудитын тайлан, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн аудит Г.Мөнхбаяр, чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Радио, телевизийн сүлжээний газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Радио, телевизийн сүлжээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Радио өргөн нэвтрүүлэг, телевизийн нэвтрүүлэг дахин дамжуулах, хэт богино долгионоор нэвтрүүлэг, FM дамжуулах, радио холбооны тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, сансрын сүлжээ байгуулах, интернэт радио, интернэт телефоны үйлчилгээгээр хангах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөлт орж ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "13.5" хувьд өөрчлөлт орж "12.5" хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 17.4 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1.5 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 255.0 сая төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	17.62	5.8	-11.85
Авлага	2.63	2.13	-00.50
Бараа материал	299.14	301.89	02.7
Биет хөрөнгө	1,070.11	824.70	-245.4
Биет бус хөрөнгө	2,779.49	2,779.49	00.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,169.00</b>	<b>3,913.97</b>	<b>-255.0</b>
Хуримтлагдсан үр дүн	-248.37	-503.39	-255.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,169.00</b>	<b>3,913.97</b>	<b>-255.0</b>

Радио телевизийн сүлжээний газар нь улсын төсөвт үйлдвэрийн газар байна. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5.7 сая төгрөг болж 11.9 сая төгрөгөөр буурсан байна. Харилцах дансны үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 2.1 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага буурснаас шалтгаалжээ. Авлагын үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Биет хөрөнгийн үлдэгдэл 301.8 сая төгрөг болж 245.4 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд Радио телевизийн үндэсний сүлжээ УҮГ-ын захирлын 2021 оны 10 сарын 8 -ны өдрийн А/31 тоот тушаалаар 2.5 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, мөн газрын даргын А/22 тоот тогтоолоор 44.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийт 47.4 сая төгрөгийн биет хөрөнгийг дээд шатны төсөв захирагчаас эрх шилжүүлэн авсан байна.

Хуримтлагдсан үр дүнгийн алдагдал 503.4 сая төгрөг болж өнгөрсөн оноос 255.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилийн алдагдалтай холбоотой байна. Энэ нь хандив тусламжийн орлого 77.7 сая төгрөгөөр буурсан, урсгал засварын зардал 9.3 сая төгрөгөөр, хангамжийн материалын зардал 1.4 сая сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Харин улсын төсвийн санхүүжилтийн орлого 12.0 сая төгрөгөөр өссөн байна.

Өнгөрсөн оноос нийт зардал 11.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс байр ашиглалттай холбоотой зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал буурсан нь гол нөлөө үзүүлжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг радио телевизийн сүлжээ, улсын төсөвт үйлдвэрийн газраас 360.4 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд нийт төсвийн зардал 360.4 сая төгрөгөөр батлагдсаны 327.7 сая төгрөгийн гүйцэтгэл гаргаж 32.7 сая төгрөг хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд эрх шилжүүлэн авсан орлого 47.5 сая, улсын төсвийн санхүүжилт 314.1 сая нийт 362.9 сая төгрөгийн орлого санхүүжилт төвлөрүүлж ажилласан бол 617.9 сая төгрөгийн зардал гаргаж 255 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ улсын төсөвт үйлдвэрийн газрын санхүүгийн үр дүн туйлын хангалтгүй байна. Тайлант хугацаанд эдийн засаг, санхүүгийн судалгаа хийж алдагдлыг бууруулах талаар хийсэн ажил, хэлэлцсэн асуудал хомс байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Шалгагдагч байгууллагад нэмэлт төсөв байхгүй байна.

#### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **3.8 Аудитын гол асуудал**

Хөвсгөл аймгийн Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 32.6 сая төгрөг буюу 9.2 хувийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: материаллаг хэмжээтэй цалин хөлс 16.0 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 0.8 сая төгрөг, эд хөгшил худалдан авах зардал 5.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр 2.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор давхар ажил эрхлэн гүйцэтгэж байсан 3 орон тооны хавсран гүйцэтгэсэн цалинг хэмнэсэн байна. Хурал цуглаан хийх, бэлэг дурсгал олгох, тавилга эд хогшил худалдан авах зэрэг зардал гаргаагүй байна. Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. Хөвсгөл аймгийн Радио, телевизийн сүлжээний газар нь 2021 онд нийт 603.4 сая төгрөгийн 50 мэдээллийг мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй ба дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өнгөрсөн онд Ихэр мөрөн аудит ХХК аудит хийж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 ширхэг программ хангамжийг данснаас хасах, дахин үнэлүүлэх, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт мөн шилэн дансны тухай хууль тогтоомжийг нь анхаарч үзэх нь зүйтэй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 8.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8.3 сая төгрөгийн алдааг залруулсан.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар НББ, тайлагналтай холбоотой санхүүгийн үр тайланд 8.3 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасныг залруулав.

### **4.1 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн радио телевизийн сүлжээний газар	1	8.3	1	8.3	-	-	-	-	-	-